

## Дүрслэх урлаг, орон нутгийн хичээлээр хорчин хатгамлын хөтөлбөрийг туршсан үр дүн

Жин Фү<sup>1</sup>, Лхагва Ариунжаргал<sup>2</sup>. \*

<sup>1</sup> БНХАУ, Тонглио хот, Үндэсний Их сургууль, Дүрслэх Урлагийн сургууль, Дүрслэх урлагийн тэнхим

<sup>2</sup> Монгол улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол Судлалын Сургууль, Боловсрол судлал арга зүйн тэнхим

\*-Холбоо барих зохиогч: mubisariunjargal@msue.edu.mn

ORCID - <https://orcid.org/0009-0007-5590-2721>

Хүлээн авсан: 2024.02.26

Засварласан: 2024.03.26

Хэвлэлтэд авсан: 2024.05.08

### Хураангуй

Техник технологийн хөгжил, даяаршилтай холбоотойгоор жижиг үндэстнүүд өөрсдийн соёлоо хадгалах, өвлүүлж үлдээх нь чухал асуудал болж байна. Үүнтэй холбоотойгоор улс орнууд олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь боловсролын хөтөлбөр, агуулгаар дамжуулан өөрсдийн соёлоо өвлүүлэх явдал юм. Тус өгүүлэлд БНХАУ-ын зүүн хэсгээр суурьшдаг хорчин ардын уламжлалт соёлын нэг болох хорчин хатгамлыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтад хэрэгжүүлэх боломжийг судалсан судалгааны үр дүнг тусгасан болно. Бид тус зорилгоо хэрэгжүүлэхийн тулд уламжлалт соёлын талаарх төрөөс боловсруулсан баримт бичиг, уламжлалт соёлтой холбоотой сургалтын агуулгад дүн шинжилгээг хийсэн ба үүний үр дүнд тулгуурлан бага ангийн дүрслэх урлаг болон орон нутгийн хичээлүүдэд туршилт хичээл зохион байгуулсан. Мөн сурагчдын хорчин хатгамлын талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлж түүндээ үндэслэн туршилт хичээлийн хөтөлбөрийг боловсруулж туршилт хичээлийг үе шаттайгаар зохион байгуулж үр дүнг тооцсон. Үр дүнг тооцохдоо сурагчдаас асуулгын аргаар 3 удаагийн судалгааг авсан ба багш нартай ганцаарчилсан ярилцлагуудыг зохион байгуулсан. Туршилт хичээлийн үр дүнд сурагчид хорчины уламжлалт соёл нь хорчин хатгамал гэдгийг мэддэг болсон. Мөн сурагчид хорчин хатгамлын хээ угалз, өнгө, үндсэн аргууд, бэлгэдэл утга санаа зэрэг үндсэн ойлголтын талаар мэддэг, таньдаг болсон.

**Түлхүүр үг:** Уламжлалт соёл · Хатгамал · Хичээл · Бүтээл

### Удиртгал

Өнөө үед техник технологийн хөгжил, даяаршил хурдацтай явагдаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор улс үндэстний өөрийн соёлыг хамгаалан авч үлдэх асуудал чухлаар тавигдаж байна.

Олон мянган жилийн туршид хүн төрөлхтөн урлагаар дамжуулан өөрийгөө



илэрхийлж ирсэн. Урлаг нь тухайн цаг үед, тодорхой орон зайд хэрхэн оршин тогтнож байсны баримт, илрэл бөгөөд нийгмийн хамтын ой санамж гэж ч үздэг (Darda, 2022, х.1066). Уламжлалт соёлыг хадгалан авч үлдэх, түгээн дэлгэрүүлэх олон арга зам байдаг бөгөөд түүний нэг нь боловсрол болох талаар ӨМӨЗО-ны Хянган аймгийн эдийн засгийн товчооны “ӨМӨЗО-ны биет бус соёлын төрөл зүйл – Хорчин хатгамлын хөгжлийн өнөөгийн байдал” бүтээлийн хоёрдугаар хэсэгт дурджээ (Хянган аймгийн эдийн засгийн товчоо, 2019, х.1). Мөн тус бүтээлд хорчин хатгамлыг өвлүүлэх сургалт нь системгүй, зохион байгуулалт муутай, сайн хатгаж урладаг чадвартай хүмүүс цөөн, санхүүгийн дэмжлэг дутмаг, уламжлан залгамжлах систем дутмаг зэрэг асуудлуудын талаар авч үзжээ (Хянган аймгийн эдийн засгийн товчоо, 2019, х.1). Өнгөрсөн үеийн соёлын үнэт зүйлсийн ач холбогдлыг ойлгосноор соёлын өвийг хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх талаар ухамсартайгаар авч үзэж байна. Энэ нь тэнцвэртэй нийгмийг бий болгоход маш чухал юм (Dilmaç, 2015, х.196).

Дүрслэх урлагийн хичээл нь “хүмүүнлэг, сурагчдын урлагийн боловсролын талаар танин мэдэх, өөр цаг үеийн соёлын урлагийн бүтээлийг хүндэтгэх, амьдрал дахь урлагийн үзэгдлийг анхаарах зэрэг сэтгэлгээг хүмүүжүүлнэ” гэсэн бол тус хичээлийн үндсэн зарчмыг “Дүрслэх урлаг бол соёл болон амьдралтай салшгүй холбоотой ба сурагч дүрслэх урлагийн хичээлээр дамжин хүн төрөлхтний баялаг соёлыг ойлгож, дүрслэх урлагийн олон янзын чанар, онцлогийг танин мэдэх ёстой. Мөн дүрслэх урлаг нь нийгмийн амьдралд онцгой хувь нэмэр үзүүлдэг ба сурагчид уламжлалт соёлоо хайрлах, дэлхийн олон янзын соёлын үзэл санааг хүндэтгэнэ хэрэгтэй” гэж тодорхойлсон байна. Харин хичээлийн зорилгыг “Ёс зүйг дээдлэх, шилдэг үндэстэн, ардын урлаг ба соёлын өвийг эрхэмлэх, үндэстний бахархлыг нэмэгдүүлэх, дэлхийн олон янзын соёлыг хүндэтгэх” гэж заасан байна (Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Боловсролын яам, 2018, х.4). Иймд бид тус судалгаагаар сурагчдын хорчин хатгамлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд тус агуулгыг хөтөлбөрт тусгаж, түүний үр дүнг тооцохыг зорьсон болно.

### **Судалгааны арга зүй**

Бид тус ажлын хүрээнд сурагчдын хорчин хатгамлын талаарх ойлголтыг илрүүлэх тандалт судалгааг асуулгын арга ашиглан судалж үүний үр дүнд үндэслэн хичээлийн хөтөлбөр боловсруулан туршсан ба судалгааны сүүлийн шатад асуулгын арга болон сурагчдаар бүтээл хийлгэн хөтөлбөрийн үр дүнг тооцсон. Дараах хэсгээс ашигласан арга зүйн дэлгэрэнгүй тайлбарыг харна уу (Зураг 1).

## Зураг 1

## Судалгааны арга зүйн схем



*Тандалт судалгааны арга зүй:* Хорчин хүүхдүүдийн уламжлалт соёл, хорчин хатгамлын үндсэн ойлголт, онцлогийн талаарх ойлголтыг илрүүлэхийн тулд 2019 оны 4 дүгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тонглио, Улаанхад, Улаанхот зэрэг хотуудын нийт 10 ерөнхий боловсролын сургуулийн эрэгтэй 246, эмэгтэй 290 сурагч нийт 536 сурагчаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Асуулга нь хорчин хатгамлын талаарх мэдлэг, бэлгэдлийн талаарх ойлголт, хичээлийн агуулга дахь уламжлалт соёлын агуулга гэсэн үндсэн 3 хэсэг, нийт 12 асуултаас бүрдсэн.

Мөн үндэсний уламжлалт соёлын агуулгыг хөтөлбөр, хичээлд тусгах, түүнийг хэрэгжүүлэх боломжийг тандах зорилгоор 10 сургуулийн дүрслэх урлагийн багш нараас судалгаа авсан болно. Асуулга нь багш нар хичээлдээ уламжлалт соёлын агуулгыг тусгаж буй туршлага, хорчин хатгамлыг хичээлийг агуулгад тусгах боломжийг зэрэг нийт 8 асуултаас бүрдсэн.

*Хичээлийн хөтөлбөр боловсруулсан арга зүй:* Бид судалгааны ажлын зорилготойгоо уялдуулан хорчин хатгамлыг бага ангийн сурагчдад таниулж мэддэг болгохын тулд тус агуулгыг тусган оруулж болох хичээлийг судлахад дүрслэх урлаг болон орон нутгийн хичээлүүдэд оруулах боломжтойг илрүүлсэн. Үүнд:

- Хорчин хатгамлын үндсэн аргууд болох хатгамал хатгах, сийлмэл - хайчилбар, зүү ороох оёдол, зээгт наамал зэрэг нь дүрслэх урлагийн хичээлд түгээмэл ашиглагддаг наах, хайчлах, оёх, хатгах, дүрслэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зэрэг үйлүүдээр хийгддэг.
- Орон нутгийн хичээлээр дамжуулан тухайн газар нутгийн уламжлалт соёлын агуулгыг тусгах боломжтой байсан. Мөн эдгээр хичээлүүдэд уламжлалт соёлын агуулгыг тусгах боломжтой эсэх талаар эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

ӨМӨЗО-ны боловсролын газраас 2009 оны 9 сарын 3-ны өдрийн 34-р тогтоол болох “Албан журмын боловсролын хичээлийн төлөвлөлт”-ийн “Хичээлийн төлөвлөлт” хэсэгт орон нутгийн хичээлийн агуулгад гар урлал, шинжлэх ухааны туршилт, Өвөрмонголын түүх ба соёл, ахуй амьдрал ба орчин тойрон, үндэстний хамтрал, улс төрийн боловсрол, гамшгаас сэргийлэх, амьдрах чадвар зэргийг багтаахаар тусгажээ.

Дээрх бичиг баримтуудад үндэслэн дүрслэх урлаг болон орон нутгийн нийт 30 цагийн “Хорчин хатгамал” туршилт хичээлийг хорчин үндэстнүүд төвлөрөн суудаг Тонглио хотын Монгол үндэстний бага сургууль, Улаанхад хотын Ар хорчин хошууны Загастай хоёрдугаар гол бага сургуулиудын 4-р болон 5-р дугаар ангид зохион байгуулсан. Нийт 55 сурагч хамрагдсан.

Туршилт хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа “суралцахуй нь мэдлэгийг идэвхгүй хуримтлуулах бус мэдээлэлтэй ажиллах, түүнийг тайлбарлах, шинэ мэдлэгээ хур мэдлэгтэйгээ холбох, өргөжүүлэн баяжуулах, өөрчлөх үйлд суурилан хөгждөг үйл явц” гэсэн конструктивизмын онол, сурагчид мэдлэгийг бүтээхдээ өөрөө тухайн агуулгыг сонирхон судалж, өөрөө туршин, хийж бүтээн мэдлэг бүтээдэг зэрэг үзэл онолд суурилсан. Мөн Япон улсын Боловсролын бодлогын хүрээлэнгээс гаргасан хөтөлбөр боловсруулах, үнэлгээ хийх аргазүйн зөвлөмж, Монголын “Дүрслэх урлаг, технологи” сургалтын хөтөлбөр, БНХАУ-ын Уран зургийн хичээлийн баримжаа зэрэгт тусгагдсан дүрслэх урлагийн хичээлийн онцлогуудыг харгалзан үзсэн (Жин Фү, 2022, х.95).

Мөн туршилт хичээлийг зохион байгуулж буй багш нартай нягт хамтран ажилласан бөгөөд бага ангид дүрслэх урлагийн чадвар, ойлголтыг хөгжүүлэх баялаг, бие даасан дүрслэх урлагийн туршлагыг хөгжүүлэх томоохон боломж байгдга. Иймд багш ангид манлайлагч гэхээсээ илүү туслагчийн үүрэг гүйцэтгэхийг шаарддаг бөгөөд энэ нь эргээд мэргэжлийн хөгжилд нөлөөлдөг (Anna Robb, 2020, х.2).

Боловсруулсан туршилт хичээлийн хөтөлбөрөөр сурагчдад дараах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхийг зорьсон. Үүнд:

- Сурагчид хорчин хатгамлын үндсэн ойлголт, өнгө, үндсэн арга, хээ угалз, түүний бэлгэдлийн талаар мэдлэгт, ойлголттой болно.
- Хорчин хатгамлын өнгийг зөв зохицуулан ашиглах, хээ угалзыг дүрслэн зурж чаддаг болно.
- Хорчин хатгамлын талаар бусдад тайлбарлаж чаддаг болно.
- Хорчин хатгамлыг өөрийн уламжлалт соёл гэж үзэн сонирхон судлах эрмэлзэлтэй, өөрийн бүтээлдээ хорчин хатгамлыг тусгах хандлагатай болно.

Дээрх үндэслэл тайлбар, арга зүйд үндэслэн нийт 30 цагийн туршилт хичээлийн хөтөлбөр боловсруулсан.

## Хүснэгт 1

## Туршилт хичээлийн сэдвийн төлөвлөлт

№	Нэгж хичээлийн сэдэв	№	Ээлжит хичээлийн сэдэв	Хичээлийн цаг
1	Хорчин хатгамлын талаарх ерөнхий ойлголт	1	Хорчин хатгамлын түүх соёл	Дүрслэх урлаг
		2	Хорчин хатгамлын төрөл	Орон нутаг
		3	Тамхины уутны хээ угалз	
		4	Тамхины уутны өнгө будаг	
2	Хорчин хатгамлын хээ угалз	5	Хорчин хатгамлын хээ угалз (алхан хээ, үүлэн хээ, тамган хээ)	Дүрслэх урлаг
		6	Хорчин хатгамлын хээ угалз (галын хээ, өлзий хээ, усан хээ)	
		7	Хорчин хатгамлын хээ угалз (зоосон хээ, эрвээхэй хээ)	
		8	Хорчин хатгамлын хээ угалз (цэцгэн хээ, шувууны хээ)	
3	Хорчин хатгамлын өнгө	9	Хорчин хатгамлын өнгө эрхэмлэх ёс	Орон нутаг
		10	Хорчин хатгамлын өнгө зохицуулах ёс	
4	Хатгамал хатгах	11	Хатгамлын тухай	Дүрслэх урлаг
		12	Хатгамлын хээ угалз, өнгө будаг	
		13	Хатгамал хатгах арга	
		14	Хорчин хатгамлын шинэ бүтээл – 1	
		15	Хорчин хатгамлын шинэ бүтээл – 2	
5	Сийлмэл - Хайчилбар	16	Сийлмэл -Хайчилбарын тухай	Дүрслэх урлаг
		17	Сийлмэл – Хайчилбар хийх арга	
		18	Сийлмэл - Хайчилбарын шинэ бүтээл – 1	
		19	Сийлмэл - Хайчилбарын шинэ бүтээл – 2	
		20	Сийлмэл – Хайчилбарын бүтээлийн танилцуулга	
6	Зүү ороох оёдол	21	Зүү ороох оёдлын тухай	Орон нутаг
		22	Зүү ороох оёдлын багаж хэрэгсэл, түүний хэрэглээ	
		23	Зүү ороох оёдлын арга	
		24	Зүү ороох оёдлын аргыг турших нь	
		25	Зүү ороох оёдлын бүтээлийн танилцуулга	
7	Зээгт наамал	26	Зээгт наамлын тухай	Дүрслэх урлаг
		27	Зээгт наамал хийх арга	
		28	Зээгт наамал хийх аргыг турших нь	
		29	Зээгт наамлын шинэ бүтээл - 1	
		30	Зээгт наамлын шинэ бүтээл - 2	

*Туршилт хичээлийн явцыг үнэлэх судалгааны арга зүй:* “Хорчин хатгамал” туршилт Хорчин хатгамлын хээ угалз” (4 цаг), “Хорчин хатгамлын өнгө будаг” (2 цаг), “Хатгамал хатгах” (5 цаг) зэрэг нийт 11 цагийн туршилт хичээл зохион байгуулсны дараа хичээлийн явцыг ажиглаж, сурагчдын суралцаж буй агуулгыг урьдчилсан байдлаар үнэлэх, хичээлийг зохион байгуулахад тулгарч буй

бэрхшээлийг тодруулах, хичээлийн хөтөлбөрийг цаашид сайжруулах зорилгоор багш сурагчдаас асуулга, ярилцлагын аргаар судалгааг авсан болно.


Явцыг үнэлэх судалгаанд туршилт хичээлд хамрагдсан 55 сурагчаас 54 сурагч оролцсон болно. Үүнээс Тонглио хотын Монгол үндэстний бага сургуулийн 15 эрэгтэй, 15 эмэгтэй нийт 30 сурагч, Ар хорчин хошууны Загастай хоёрдугаар гол бага сургуулийн 11 эрэгтэй, 13 эмэгтэй нийт 24 сурагч оролцсон.

*Туршилтын үр дүнг тооцох судалгааны арга зүй:* Судалгааг туршилт хичээлүүдийг зохион байгуулж дууссаны дараа буюу 2020 оны 7 сард авсан болно. Судалгаанд туршилт хичээлд “Тонглио хотын үндэстний бага сургууль”, “Ар хорчин хошууны Загастай хоёрдугаар бага сургууль”-ийн 5,6 дугаар ангийн нийт 55 сурагч оролцсон. Үүнээс Тонглио хотын үндэстний бага сургуулийн 30 сурагч, Ар хорчин хошууны Загастай хоёрдугаар бага сургуулийн 25 сурагч оролцсон болно. Мөн туршилт хичээлийн ололттой болон сайжруулах зүйлсийг тодруулах зорилгоор туршилт хичээл зохион байгуулсан 2 багштай ганцаарчилсан ярилцлага хийж үр дүнг боловсруулсан.

*Сурагчдын бүтээлийн үнэлгээний шалгуурыг боловсруулсан арга зүй:* “Хорчин хатгамал” туршилт хичээлийн үр дүнг үнэлэх зорилгоор сурагчдаар хорчин хатгамалтай бүтээл хийлгэсэн. Ингэхдээ сурагчдад ууж, тамхны уут, гутал, тэрлэгэн дээл зэргийн зургийг санал болгосон ба сурагчид сонгосон зургаа өөрсдийн төсөөлөл, бодлоор дизайнчилж, чимэглэж, будаж, нааж, хайчилсан. Тус бүтээлийн үнэлгээ нь бүтээлд уламжлалт соёлын агуулга илэрч байгаа эсэхийг тодруулах зорилготой байсан учир сурагчдад тус агуулгыг талаар огт дурдалгүй, бие даан гүйцэтгүүлсэн.

## Зураг 2

Сурагчид бүтээл хийхэд сонгосон загвар зургууд



Сурагчдын бүтээлийг үнэлэхдээ “Writing Effective Assessment Criteria”, “Үнэлгээний стандарт боловсруулалт, үнэлгээний аргыг сайжруулахад хэрэглэх материал”( Японы боловсролын бодлогын судалгааны газар, 2011), “Дүрслэх урлагийн боловсрол” (Тацүжи Хатано, 2019) зэргийн судалгаа болон өөрсдийн боловсруулсан хичээлийн хөтөлбөр, хүрэх үр дүнгүүддээ үндэслэн шалгуур үзүүлэлт бүхий үнэлгээний рубрик боловсруулсан.

Харин Монголын “Дүрслэх урлаг, технологи” сургалтын хөтөлбөр (Боловсролын хүрээлэн, 2019) үнэлгээ хийх зөвлөмжид дүрслэх урлагийн хичээлийн үнэлгээг хийхдээ сурагчийн мэдлэг, ойлголт, мэдлэгээ хэрэглэх чадвар, хандлага (сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлэх) зэргийг үнэлэхээр тусгажээ.

### Зураг 3

Сурагчдын бүтээлийн үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуур үзүүлэлт		
Мэдлэг	Дүрслэх чадвар	
<ul style="list-style-type: none"> <li>➢ Хорчин хатгамлын талаарх үндсэн ойлголт</li> <li>➢ Хорчин хатгамлын өнгө</li> <li>➢ Хорчин хатгамлын үндсэн аргууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хорчин хатгамлын үндсэн дүрслэл</li> <li>➢ Бүтээлийн өнгө будаг</li> <li>➢ Хорчин хатгамлын хээ угалз</li> <li>➢ Бүтээл дэх орон зайн дүрслэл</li> </ul>	
Хэрэглээ	Бүтээлч чадвар	Хандлага
<ul style="list-style-type: none"> <li>➢ Тухайн эд хэрэглэлийн хэрэглээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Хорчин хатгамлын үндсэн хэлбэрт бүтээлчээр хандсан байдал</li> <li>➢ Хорчин хатгамлын хэлбэрийг бүтээлчээр өөрчилсөн байдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Бүтээл хийх сонирхол хүсэл эрмэлзэл</li> </ul>

### Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Бид дээрх арга зүйн хүрээнд судалгааны мэдээллүүдийг цуглуулсан ба дараах хэсэгт дэлгэрэнгүй үр дүнг танилцуулах болно.

#### Тандалт судалгааны үр дүн


Судалгаагаар сурагчид хорчин хатгамлын талаар мэддэг эсэхийг тандахад 124 сурагч буюу нийт сурагчдын 23.1% нь “мэднэ”, 225 сурагч буюу нийт сурагчдын 42% нь “бага зэрэг мэднэ”, 187 сурагч буюу нийт сурагчдын 34.9% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

Асуулгын эхний хэсэгт сурагчдаас олон хатгамал дотроос хорчин хатгамлыг ялгаж таньж чадах эсэхийг тодруулахад 48% нь ялгаж чадахгүй гэсэн хариултыг сонгосон. Харин энэ хэсэгт хатгамалтай хувцас, эдлэл хэрэглэлийн зургуудаас хорчин хатгамлыг таньж байгаа эсэхийг тодруулахад 1 зөв хариултыг 225 (42%) сурагч, 2 зөв хариултыг 89 (16.6%) сурагч, 3 зөв хариултыг 51 (9.5%) сурагч, харин огт буруу хариултыг 171 (31.9%) сурагч тус тус сонгосон байна.

Хорчин хатгамалд хөх, цагаан, ногоон өнгийг эрхэмлэдэг бөгөөд сурагчдаас тус 3 өнгийг 46 (8.6%) сурагч сонгосон байсан. Мөн 1 зөв хариултыг 246 (45.9%) сурагч, 2 зөв хариултыг 116 (21.7%) сурагч, буруу хариултуудыг сонгосон 128 (23.8%) сурагч тус тус байсан. Хорчин хатгамалд түгээмэл илэрдэг хээ угалзыг тодруулахад сурагчид дараах хариултыг өгсөн байна.

## Зураг 4

Сурагчдын хорчин хатгамлын хээ угалзын мэдлэг



дүнгээс үзэхэд сурагчдын хариултын хувь ойролцоо буюу нэг хариултыг ойролцоогоор 100 гаруй сурагч сонгосон нь судалгаанд оролцсон нийт сурагчдын хувьд харьцуулахад хангалтгүй үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл 536 сурагчийн 20 гаруй хувь нь л хорчин хатгамалд ашиглагддаг 1-2 хээг таньж байгаа гэсэн үг юм.

Сурагчид хорчин хатгамлын талаар мэдэж буй эсэхийг тодруулах зорилготой асуулгын аргаар авсан судалгааны үр дүнд сурагчдын хорчин хатгамлын талаарх ойлголт, түүний өнгө будаг, хорчин хатгамалтай эд зүйлийг таньж байгаа нь хангалтгүй байгааг илрүүлээ.


Багш нараас авсан судалгааны үр дүнг харахад судалгаанд оролцсон багш нарын дийлэнх хувь буюу 80% нь хүүхдүүд уламжлалт соёл болох хорчин хатгамлын талаар мэддэг байх нь чухал гэж үзсэн байна. Харин дүрслэх урлагийн хичээлд орон нутгийн онцлогтой агуулга оруулахыг 7 багш дэмжиж, 2 багш туршиж үзэхийг дэмжжээ.

*Туршилт хичээлийн явц, үр дүн:*

Сурагчдаас цагаан өнгөний бэлгэдлийг асуухад 50 сурагч буюу нийт сурагчдын 92.6% нь цэвэр ариун, 48 сурагч буюу 88.9% нь үнэнч цагаан, 34 сурагч буюу 63% нь сайн сайхан гэсэн хариулууд өгсөн байна. Мөн сурагчид буруу хариулт болох муу муухай гэсэн хариултыг огт сонгоогүй байгаагаас үзэхэд сурагчид цагаан өнгөний бэлгэдэл утга санааг сайн ойлгосон гэж дүгнэж болохоор байна.

## Зураг 5

Сурагчдын хорчин хатгамлын хээ угалзын мэдлэгт гарсан өөрчлөлт





Дээрх судалгааны үр дүнгээс харахад сурагчид хорчин хатгамалд илэрдэг ургамлын хээ угалзыг таньж чаддаг болсон байна. Байдлыг тогтоох судалгаа болон туршилт хичээлийн явцын үр дүнг үнэлэх судалгааны үр дүнтэй харьцуулахад сурагчид хорчин хатгамлын хээг таньж чаддаг болсон байна.

Туршилт хичээлд оролцсон 55 сурагч байдлыг тогтоох судалгаанд хорчин хатгамалтай бүтээлийн зургуудаас 1 зөв хариултыг 24 (43.6%) сурагч, 2 зөв хариултыг 15 (27.3%) сурагч, бүх зөв хариултыг 9 (16.4%) сурагч, огт буруу хариултыг 7 (12.7%) сурагч тус тус сонгосон байна.

Явцын судалгаанд хорчин хатгамалтай эдлэлийг дугуйлуулахад 1 зөв хариултыг 7 (13%) сурагч, 2 зөв хариултыг 19 (35.2%) сурагч, 3 зөв хариултыг 28 (51.8%) сурагч тус тус сонгосон байна. Дээрх үр дүнгээс сурагчид хорчин хатгамалтай эдлэлийг таних чадварт нь ахиц гарсан нь харагдаж байна.

*Туршилт хичээлийн дараах сурагчдын ойлголтыг илрүүлсэн судалгааны үр дүн:* Туршилт хичээлийн дараах сурагчдын ойлголтыг илрүүлэх судалгааны асуултууд нь сурагчдын хичээлээр эзэмшсэн мэдлэгийг үнэлж чадаж байгаа эсэхийг тодорхойлоход 1-11 дүгээр асуултуудын Кронбах альфа үзүүлэлт нь 0.7-аас их байгаа нь тус асуултууд нь сурагчдын эзэмшсэн мэдлэгийг илрүүлж чадахуйц байгааг илэрхийлж байна.

Сурагчдын хорчин хатгамлын талаарх мэдлэгийг байдлыг тогтоох судалгаа болон, туршилт хичээлийн дараах судалгаагаар үнэлүүлсэн ба сайн мэднэ гэсэн хариулт 40% байсан бол 58.2%, дунд зэрэг гэсэн хариулт 49.1% байсан бол 40%, огт мэдэхгүй гэсэн хариулт 10.9% байсан бол 1.8% болж тус тус өөрчлөгдөж сурагчдын хорчин хатгамлын талаарх ойлголтод ахиц гарсан байна.

Сурагчид байдлыг тогтоох судалгаанд өнгийг 1 зөв хариултыг 23 (41.8%) сурагч, 2 зөв хариултыг 19 (34.5%) сурагч, 3 зөв хариултыг 6 (11%) сурагч, огт буруу хариултыг 7 (12.7%) сурагч тус тус сонгосон байна. Мөн сурагчдад өнгөний зохицлын жишээ өгөхөд 92.6% нь зөв хариултыг сонгосон байна. Иймд сурагчдын өөрийн үнэлгээ, гүйцэтгэлийг харьцуулахад тухайн жишээний хувьд авч үзвэл сурагчийн гүйцэтгэл илүү өндөр байна.

Сурагчдаар өөр өөр хээ угалз дүрс бүхий даалингуудаас хорчин хатгамалд түгээмэл илэрдэг лянхуа цэцгийн хатгамалтай даалинг сонгуулсан. Сурагчдын 78.2% нь зөв хариултыг сонгосон.

Асуулгын сүүлийн хэсэгт сурагчид туршилт хичээлээр дамжуулан хорчин хатгамлын талаар юуг илүү мэддэг болсон, хорчин хатгамлын юунд илүү дуртай болсон зэргийг нээлттэй асуултаар тодруулж хариултуудыг ангилсан.

Сурагчдын “Та хорчин хатгамлын юуг илүү мэддэг болсон бэ? гэсэн нээлттэй асуултын хариултуудыг ангилж үзэхэд сурагчдын 25.6% хорчин хатгамлын хээ угалзыг илүү мэддэг болсон, 25.6% нь хорчин хатгамлын үндсэн аргуудыг мэддэг болсон, 12.7% нь хорчин хатгамлын өнгө будгийг мэддэг болсон, 10.9% нь Монгол хувцсан дээрээс олж харах болсон, 3.6% нь дүрслэх урлагийн хичээлд дуртай болсон гэж тус тус хариулжээ. Дээрх хариултуудаас үзэхэд туршилт хичээлийн үндсэн агуулга болох хорчин хатгамлын хээ угалз, үндсэн аргууд, өнгө будгийг мэддэг болсон гэсэн хариултыг бусад хариултуудтай

харьцуулахад олон сурагч өгсөн байна. Тус үр дүнгээс үзэхэд туршилт хичээлийн зорилгын нэг хэсэг биелснийг илэрхийлж байна гэж үзэж байна.

Мөн хорчин хатгамлыг хаанаас харж таних болсон бэ? гэсэн нээлттэй асуултын хариултуудыг ангилж үзэхэд сурагчдын 29.1% нь хорчин хатгамалтай хувцаснаас, 16.4% нь гутал дээрээс, 12.7% нь дүрслэх урлагийн хичээлээс, 10.9% нь сурах бичгээс, 3.6% нь гэрт байгаа эд зүйлээс, 3.6% нь интернэтээс зэрэг хариултуудыг өгсөн байна. Ийнхүү олон төрлийн эх сурвалж бичсэн нь сурагчид хорчин хатгамлыг олон зүйлээс харж ажиглаж, таньдаг болсныг илэрхийлэл болж байна. Дээр дурдсанчлан туршилт хичээлийг зохион байгуулсан 2 багштай туршилт хичээлийн ололттой тал болон цаашид анхаарах зүйлсийг тодруулахаар ганцаарчилсан ярилцлага хийсэн бөгөөд ярилцлагын үр дүнг дараах хэсгээс харна уу.

- *Бага сургуулийн дүрслэх урлаг, орон нутгийн хичээлд уламжлалт соёлын агуулгатай хичээлийг орж байгаа нь шинэлэг байсан. Мөн хорчин хатгамлын хичээлийг орж байгаа нь уламжлалт соёлыг өвлүүлэн хөгжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзсэн байна.*
- *Хичээлд тулгарч буй асуудлын хувьд туршилт хичээлд ашиглаж буй хорчин хатгамалтай эдлэл хэрэглэлийн тоог нэмэгдүүлэх, мөн хичээлийн агуулгыг хэт гүнзгий бус бага ангийн хувьд хорчин хатгамлыг хийж сургах бус түүнийг ойлгуулах, таниулах тал дээр анхаарах нь чухал байна.*
- *Туршилт хичээлийг зохион байгуулж байгаа нэг багш нь сурагчдын хийж буй үйлдэл нь хүйсээрээ ялгаатай байгааг дурдсан бол нөгөө багш сурагчид хорчин хатгамлын өөр өөр аргуудыг сонирхож байгааг хэлсэн байна. Үүнээс үзэхэд сурагчдын онцлогийг дараа дараагийн хичээлд харгалзан үзэх нь чухал байна.*
- *Цаашид хичээлд ямар арга ашиглавал илүү сайн байх тал дээр бодит зүйл дээрээс сурагчдад жишээ үзүүлэх, мөн компьютер ашиглан сурагчдад хорчин хатгамлын арга мэргэжлийг үзүүлбэл сайн гэж үзсэн байна.*

*Сурагчдын бүтээлийн үнэлгээний үр дүн:*

Дээрх үнэлгээний шалгууруудын найдвартай байдлыг шинжлэхэд Кронбах альфа үзүүлэлт 0.917 ( $n = 11$ ) гарсан нь сурагчдын бүтээлийг үнэлэх шалгуурууд найдвартай байгааг илэрхийлж байна. Сурагчид хорчин хатгамлын үндсэн ойлголт, тухайн бүтээлийн хэрэглээний үзүүлэлт нь бусад шалгуур үзүүлэлттэй харьцуулахад өндөр буюу сайн байна. Харин “Бүтээл дэх орон зайн дүрслэл”, “Хорчин хатгамлын үндсэн арга” үзүүлэлтийн дундаж нь бусад шалгуурын үр дүнтэй харьцуулахад бага байна. Энэ нь орон зайн дүрслэл зэрэг дүрслэх урлагийн үндсэн агуулгыг туршилт хичээлдээ төдийлөн тайлбарлаагүйгэй холбоотой байх магадлалтай.

## Хүснэгт 2


Сурагчид бүтээлдээ хорчин хатгамлын аргуудыг ашигласан байдал

Үнэлгээний үзүүлэлт	Давтамж	Эзлэх хувь
Хорчин хатгамлыг хийдэг аргуудыг хэрэглэж бүтээл нь бүрэн гарсан ба өөрийн бодож гаргасан хувилбарыг нэмж гаргасан	3	5.5%
Хорчин хатгамлыг хийдэг аргуудыг хослуулсан боловч бүтээл нь бүрэн гараагүй	18	32.7%
Хорчин хатгамлыг хийдэг аргыг хэрэглэж бүтээл нь бүрэн гарсан	30	54.5%
Хорчин хатгамлыг хийдэг аргуудаас ашигласан боловч бүтээл нь бүрэн гараагүй	4	7.3%
Нийт	55	100.0

Сурагчдын хийсэн бүтээлийг үнэлэхдээ хорчин хатгамлын үндсэн аргуудыг ашигласан байдлын үр дүнг нэгтгэхэд 92.7% буюу дийлэнх сурагч нь хорчин хатгамлыг хийдэг аргуудыг мэддэг болсныг илэрхийлж байна. Цаашид хорчин хатгамлын туршилт хичээлийг зохион байгуулахдаа хорчин хатгамлын аргуудыг таниулахаас гадна сурагчдаар туршиж үзүүлэхээр төлөвлөхөд анхаарах хэрэгтэй байна. Хорчин хатгамлын өнгө будаг, түүнийг бүтээлдээ тусгаж буйг үнэлэхэд сурагчдын дийлэнх нь буюу 83.6% нь бүтээлийн өнгөний зохицлыг тодорхой хэмжээнд гаргасан бол нийт сурагчдын 52.7% нь өнгөний зохицлыг бүрэн зөв гаргасан байна. Эдгээрээс дүгнэхэд сурагчид хорчин хатгамлын өнгө зохицлын талаарх үндсэн ойлголттой болсон нь харагдаж байна.

## Зураг 6

Сурагчид бүтээлдээ хорчин хатгамлын хээ угалзыг тусгасан байдал



Сурагчдын бүтээлд хорчин хатгамлын үндсэн хэсэг болох хээ угалз туссан байдлыг үнэлэхэд 30 сурагчид буюу нийт 54.6% нь хорчин хатгамлын 2-с дээш хээ угалзыг бүтээлдээ тусгасан бол 40% нь нэг хээг тусгасан байна. Ийнхүү сурагчдын 94.6% нь хорчин хатгамлын хээ угалзыг ямар нэгэн байдлаар бүтээлдээ тусгаснаас үзэхэд хорчин хатгамлын хээ угалзыг тодорхой хэмжээнд мэддэг болсныг харуулж байна.

## Хүснэгт 3

## Сурагчид бүтээлдээ бүтээлчээр хандсан байдал

Үнэлгээний үзүүлэлт	Давтамж	Эзлэх хувь
Бүтээлд хорчин хатгамлын үндсэн хэлбэрээс өөр зүйлийг нэмж зохистойгоор оруулан өвөрмөц шинэ санааг илэрхийлсэн	9	16.4%
Бүтээлд хорчин хатгамлын үндсэн хэлбэрээс өөр зүйлийг нэмж зохистойгоор оруулан бүрэн утга илэрхийлсэн	24	43.6%
Бүтээлд хорчин хатгамлын үндсэн хэлбэрээс өөр зүйлийг нэмж зохистойгоор оруулсан	17	30.9%
Бүтээлд хорчин хатгамлын үндсэн хэлбэрээс өөр зүйлийг нэмж оруулсан	5	9.1%
Нийт	55	100%

Сурагчид бүтээлдээ хорчин хатгамлын онцлогийг тусгахаас гадна бүтээлдээ өнгө будаг, хээ угалз, дүрсийг зохицуулан бүтээлчээр, өвөрмөцөөр хэрхэн хандаж байгааг үнэлгээний нэгэн шалгуур үзүүлэлт болгосон. Дээрх үр дүнгээс харахад сурагчдын дийлэнх хувь нь өөрийн бүтээлдээ шинэ санаа тусгахыг оролдсон болох нь харагдаж байна.

**Дүгнэлт**

БНХАУ-ын соёлын хөгжлийн төлөвлөгөөний тойм, Боловсролын яамны бодлого, ӨМӨЗО-ны боловсролын бодлого зэрэгт уламжлалт соёл байдлыг судлахад уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өвлүүлэх, таниулах талаар дэлгэрэнгүй тусгажээ (Ариунжаргал ба Жин Фү, 2020, х.55). Гэтэл энэ үнэт зүйлс болох уламжлалт соёлоо хүүхэд багачууд мэдэхгүй болсон нь судалгаанаас тодорхой харагдаж байна. Бид сурагчдад хорчин хатгамлыг таниулах, мэдүүлэх зорилготой туршилт хичээлийн хөтөлбөр боловсруулан туршсан ба тус хөтөлбөрт сурагчдад хорчин хатгамлын талаарх ерөнхий ойлголт, өнгө, хээ угалз, түүний бэлгэдэл, үндсэн аргуудын агуулгыг багтаан төлөвлөсөн. Тус туршилт хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулахад сурагчид уламжлалт соёл болох хорчин хатгамлыг таньдаг, мэддэг, хэрэглээний талаар ойлголттой болсон учраас тус туршилт хичээл нь эерэг үр дүнтэй байсан гэж дүгнэж байна.

- Туршилт хичээлийг зохион байгуулсны үр дүнд сурагчид хорчины уламжлалт соёл нь хорчин хатгамал гэдгийг мэддэг болсон. Мөн сурагчид хорчин хатгамлын хээ угалз, өнгө, үндсэн аргууд, бэлгэдэл утга санаа зэрэг үндсэн ойлголтын талаар мэддэг, таньдаг болсон.
- Сурагчид туршилт хичээлээр хорчин хатгамалтай эдлэл хэрэглэлийг таньдаг болсон. Тухайлбал сурагчид хүрээлэн буй орчноосоо буюу хувцаснаас, хичээлээс, гэрт байгаа зүйл, интернэтээс зэрэг олон төрлийн эх сурвалжуудаас хорчин хатгамлыг ажиглаж, таньдаг болсныг судалгааны үр дүнгээс харж болно.

- Туршилт хичээлээр дамжуулан сурагчид хорчины уламжлалт соёлын талаар мэдэж, хорчин хатгамалтай эдлэл хэрэглэлийн хэрэглээний талаар ойлголттой болсон байна.
- Сурагчид хорчин хатгамлын агуулгыг тусгасан бүтээлийг өөрийн хэмжээнд хийх чадвартай болсон нь сурагчдын 94.6% нь хорчин хатгамлын хээ угалзыг бүтээлдээ дүрсэлснээс, 92.7% нь хорчин хатгамлыг хийдэг аргуудыг хэрэглэснээс харагдаж байна.

### Талархал

Тус судалгаа нь Иргэний хэргийн комиссын Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны судалгааны төв, Хятадын Умард үндэстний соёл урлагийг хөгжүүлэх судалгааны төвөөс 2021 оноос хойш хэрэгжүүлж буй төслүүдийн нэг болох “Хорчин тамхины уут ба дэрний хатгамлын соёл урлагийн хөгжил” төслийн хүрээнд хийгдсэн болно (судалгааны төслийн дугаар: 2021BJDY006).

### Ашигласан бүтээлийн жагсаалт

- Ариунжаргал, Л., Жин Фү. (2020). БНХАУ-ын боловсролын баримт бичиг, дүрслэх урлагийн хичээлийн стандарт, сурах бичиг дэх уламжлалт соёлын агуулгын судалгаа. *Боловсрол судлал сэтгүүл*, 08(166), 55-64.
- Боловсролын хүрээлэн. (2019). *Дүрслэх урлаг, технологи” сургалтын хөтөлбөр*. Улаанбаатар.
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Боловсролын яам. (2018). *Албан журмын сурган хүмүүжлийн уран зургийн хичээлийн стандарт*. Хөх хот:ӨМӨЗО-ны сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Тацүжи Хатано, Мияке Шигэо. (2019). *Дүрслэх урлагийн боловсрол*. Токио: Минерва хэвлэлийн компани.
- Японы боловсролын бодлогын судалгааны газар. (2011). *Үнэлгээний стандарт боловсруулалт, үнэлгээний аргыг сайжруулахад хэрэглэх материал*. Токио: Гёосэй хэвлэлийн газар.
- Anna Robb, Divya Jindal-Snape, Susan Levy. (2020). Art in my world: Exploring the visual art experiences in the everyday lives of young children and their impact on cultural capital. *Child and Society*. 2021(35).90-109. doi: <https://doi.org/10.1111/chso.12392>
- Darda, K.M., Cross, E.S. The role of expertise and culture in visual art appreciation. *Sci Rep* 12, 10666 (2022). <https://doi.org/10.1038/s41598-022-14128-7>
- Dilmaç, O. (2015). *Değerlerin Kazandırılmasında Sanat Eğitiminin Rolü [The Role of Art Education in Acquisition of Values]*. H.H. Bircan ve B. Dilmaç (Ed.). Değerler Bilançosu [Balance of Values], (p. 299-310). Konya: Cizgi Publications

## The "Khorchin" embroidery result was experimented with in fine arts and local courses

Jin Fu<sup>1</sup>, Ariunjargal Lkhagva<sup>2,\*</sup>

<sup>1</sup>*Department of Fine Arts, School of Fine Arts of Inner Mongolia Minzu University, China*

<sup>2</sup>*Department of Educational studies and methodology, School of Educational Studies, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

\*-Corresponding author: mubisariunjargal@msue.edu.mn

ORCID - <https://orcid.org/0009-0007-5590-2721>

---

Received: 2024.02.26

Revised: 2024.03.26

Accepted: 2024.05.08

---

### Abstract

Protecting and inheriting the culture of small nations with the development of technology and globalization is an important issue. One that takes up a lot of operational resources is the legacy of educational programs and content tools. The article reflects the results of a study on the possibility of implementing khorchin embroidery, one of the traditional cultures of the khorchin people living in the eastern part of China, in teaching secondary education schools. To achieve this goal, we analyzed government documents on traditional culture and educational content related to traditional culture. Based on these results, the organization of pilot lessons in elementary visual arts and local subjects. Also, the student's knowledge and understanding of needlepoint embroidery were discovered. Based on that, an experimental lesson program was developed, the practical lesson was organized in stages, and the results were calculated. As a result of the research, it was revealed that the pilot lesson was successful and effective because the students tended to respect the characteristics, symbols, patterns, usage, and traditional culture of embroidery. In order to calculate the results, 3 surveys were conducted from the students and in-depth-interview with the teachers were held. As a result of the experimental lesson, the students learned that the traditional culture of khorchin is khorchin embroidery. Also, the students are familiar with the basic concepts such as patterns, colors, basic methods, and symbols of embroidery.

**Keywords:** Traditional culture · Embroidery · Lessons · Creature